



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хатанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/91/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: Gan-Ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Ч.Хэрлэнчимэг Утас: 70523020 Цахим хаяг: Kherlenchimegch@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.08.24 № 46/94

танай _____-ны № _____-т

ХАТАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Б.НАВЧАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хатанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хатанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд тус байгууллага нь 3.5 сая төгрөгийн төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Тухайлбал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас уралдаант тэмцээний шагналд 1.8 сая төгрөгийг, цалин хөлсний зардлаас ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 1.2 сая төгрөгийн зарцуулсан байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын эдийн засгийн ангилал баталсан 2014 оны 55 дугаар тушаал, 2021 оны 190 дүгээр тогтоолтой нийцэхгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	9.4	11.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	15.5	14.2
	Нийт хөрөнгийн дүн	24.9	25.4
	Нийт өр төлбөрийн дүн	0.3	0.2
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	24.6	25.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	24.9	25.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	110.6	103.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	97.8	103.2
	Үйл ажиллагааны үр дүн	12.8	0.6
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	(0.0)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	12.8	0.6
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11.8	24.6
	Тайлант оны үр дүн	12.8	0.6
	Эцсийн үлдэгдэл	24.6	25.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	110.6	103.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	99.1	100.7
	Үйл ажиллагааны ЦМГ	11.5	3.1
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(11.5)	(3.1)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	103.8	93.9
	Урсгал зардал	103.8	93.9
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	103.8	93.9
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	103.8	93.9
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хатанбулаг сумын ИТХ нь Монгол Улсын хуулиудад заагдсан эрх үүргийн биелэлтийг ханган, орон нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн байдалд төлөөлөгчдөөр дамжуулан иргэдийн хяналт, оролцоог дээшлүүлэх, иргэдэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгааг бий болгох, бодлого шийдвэрийг боловсруулан хэрэгжүүлэх, эхэлсэн ажлуудын тогтвортой байдлыг хангуулах үндсэн чиг үүрэгтэй.

Тус байгууллага нь дараах зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд,

- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны үйл ажиллагааг сумын хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглүүлэн, хүртээмжтэй зохион байгуулан, хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангуулна.
- Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны үйл ажиллагааг шуурхай хангаж, ИТХ-д хуулиар олгогдсон бүрэн эрх, үүргийн хүрээнд орон нутаг болон иргэдийн ашиг сонирхолд нийцүүлсэн бодлого боловсруулж, оновчтой шийдвэр гарган ажиллана.
- Төлөөлөгч, хурлын хороодыг идэвхжүүлэн, хуралд хуулиар олгогдсон хяналт шалгалтын ажлын үр дүнг дээшлүүлэн, хуулийн хэрэгжилт, сумын эдийн засгийн чадавхыг сайжруулахад нөлөөлж ажиллана.
- Хурлын төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ төлөөлөгч, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах замаар иргэдийн идэвх оролцоог дээшлүүлнэ.
- ИТХ-ын үйл ажиллагаа, гарсан шийдвэрийг олон нийтэд шуурхай хүргэж, тэмдэглэлт өдөр, хууль тогтоомжийг сурталчлах нөлөөллийн ажлуудыг гүйцэтгэж, хурал болон иргэдийн хамтын ажиллагааг сайжруулна.
- Хурлын ажлын албаны шуурхай байдлыг ханган, нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэхэд шаардагдах ажлыг зохион байгуулна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллагын нягтлан бодогч 3 удаа солигдсон байна. Тус байгууллага нь 2021 оны 11 дүгээр сард улс, аймаг, сумын аварга малчдын 85 хүнийг хамруулсан зөвлөгөөн, хурал зохион байгуулсан байна.

Тус байгууллага нь автомашины сэлбэг, хэрэгсэлд 3.2 сая төгрөгийг тайлант онд зарцуулсан ба үүнээс өөрийн эзэмшилд байдаг УАЗ-31512 маркийн автомашинд 1.0 сая төгрөгийн засвар хийж, үлдэх 2.2 сая төгрөгийн засварын зардлыг тус сумын Засаг даргын тамгын газрын эзэмшилд байдаг Ланд-105 маркийн автомашинд зарцуулсан байна. Ланд-105 маркийн автомашин нь ИТХ-ын эзэмшилд байдаггүй ч шаардлагатай үед тус хөрөнгийг ашиглаж, хэрэглэдэг байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн батлагдсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах талаар тусгасан байтал ИТХ-ын тэргүүлэгч, төлөөлөгчдийн хурал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн хурал, баримт бичиг нягтлан шалгах комиссын хурлыг зохион байгуулахад 3.4 сая төгрөгийн хоолны зардал гаргаж, төсвийг үрэлгэн, үр ашиггүй зарцуулсан байна. Үүнээс гадна, малчдын зөвлөгөөн зохион байгуулахад хичээл үйлдвэрлэлийн зардлаас 2.0 сая төгрөгийг хоол, хүнс бэлтгэхэд зарцуулсан байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 58.4 сая төгрөгийн 8 орлогын гүйлгээ, хөрөнгө, төсөв зарцуулахтай холбоотой 11.8 сая төгрөгийн 11 тушаалыг шилэн дансны цахим системд байршуулахаар байна. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авах ажиллагаа, зарлагын гүйлгээ бүртгэгдээгүй байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад цалингийн зардлаас бусад, 5.0 сая төгрөгөөс дээш орлогын гүйлгэг бүрэн байршуулсан, 0.1 сая төгрөгийн төсөв зарцуулах 1 тушаалыг байршуулаагүй, 0.4 сая төгрөгийн 1 тушаалыг хугацаа хоцроож байршуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад ашиглагддаг, юнителийн 4 интернэтийн /гэр интернэтийн дугаар/ төлбөрийг урьдчилсан төлсөн байна. Үүнд, юнителийн 2 интернэтийн төлбөрийг 2022.04.29-ны өдрийг хүртэл төлсөн, 1 интернэтийн төлбөрт 190,166 төгрөгийг илүү төлсөн, 1 дугаарын төлбөрийг 2022.03.26-ны өдрийг хүртэл төлсөн байна. Иймд дараагийн аудитаар интернэтийн төлбөрийг 2022 онд давхардуулан шилжүүлсэн байж болзошгүй горим, сорилыг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 13.8 сая төгрөгийн 10 алдаа зөрчил илэрч, аудитын явцад 9.6 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 3.8 сая төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага, 0.4 сая төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгсөн.

Аудитын явцад зардлын ангилал буруу бүртгэсэн 6.2 сая төгрөгийн 34 гүйлгээ, бараа материалын үлдэгдэл буруу ангилан бүртгэсэн 3.5 сая төгрөгийн 19 нэр төрлийн хөрөнгийг зардлын ангилал болон бараа материалын дансанд залруулсан.

Төсвийг зориулалт бусаар зарцуулсан 3.5 сая төгрөгийн зөрчил, өглөг, авлагын үлдэгдлийн тооцоо нийлж баталгаажуулаагүй 0.3 сая төгрөгийн зөрчил, төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчилд нийт 3 албан шаардлага өгсөн.

Үндсэн хөрөнгийн элэгдэл илүү тооцсон 0.1 сая төгрөгийн, хуримтлагдсан элэгдлийг зөрүүтэй бүртгэсэн 0.4 сая төгрөгийн, элэгдэл тооцоогүй 0.7 сая төгрөгийн, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 23.4 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүй зөрчилд нийт 4 зөвлөмж өгсөн.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Ауди тад хамр	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	10	13.8	2	9.6	-	-	3	3.8	4	0.4
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	10	13.8	2	9.6	-	-	3	3.8	4	0.4

Жич: Өглөг болон авлагын үлдэгдэлд 2 горим, сорил хэрэгжүүлсэн учир илэрсэн алдаа, зөрчлийн дүнг тусад нь бүртгэсэн ба зөрчлийн утга ижил учир 1 албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн. Иймд алдаа, зөрчлийн нэгтгэлд илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн тоо 1-ээр зөрүүтэй илэрхийлэгдсэн болно.